

АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

(2024 оны жилийн эцэс)

2024.12.31

Хэрлэн сум

№	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Үнэлгээ
2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар Шар усны үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай				
1	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хүн, хүч техник хэрэгслийн бодит судалгаанд үндэслэн тодотгол хийх, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, тусгайлан үерийн гамшгийн үед дайчлан ажиллуулах хүнд даацын техник, машин механизм, ус соруулах төхөөрөмж хийж, үүдийн судалгааг нарийвчлан хийж бүртгэл хөтлөх, урьдчилсан гэрээ хэлцэл хийж бэлэн байдлыг хангах	Сумын Засаг дарга нарт	Тайлант хугацаанд сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тодотголыг 2 удаа хийж гүйцэтгэсэн. Мөн “Шар усны үер, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г сумын Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.	90
2	Үерийн эрсдэл бүхий газруудад суурьшсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамгаалах чиглэлээр инженерийн болон инженерийн бус арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авах	Сумын Засаг дарга нарт	Хур тундас ихтэй жилүүдэд сумын хэмжээнд тогтоол усанд автдаг байршлууд болон голын ус эргээ даван халихад усанд автдаг айл өрх, цэгүүдийн байршлыг координатыг тогтоогоод байна. Нийт 63 өрхийн 226 иргэн эрсдэл бүхий газарт суурьшсан талаарх судалгаа гаргаж аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлсэн. Хэрлэн гол нийт уртын дагуу үерийн аюултай түвшинг даван үерлэсний улмаас тус сумын 2, 3 дугаар багийн нутаг дэвсгэр Хэрлэн, Бат-Уул хорооллын орчим зарим айл өрхүүд усанд автсан. Иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог хангах үүднээс 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдөр 2 дугаар багийн 26 өрхийг	90

			аюулгүй бүсэд нүүлгэн шилжүүлж, 7 өрхийг аймгийн Орон нутгийн өмчийн газар, ЖДҮ-г дэмжих төвийн өмчлөлийн байруудад түр байрлуулсан. Мөн 08 дугаар сарын 23-ны өдөр Чойбалсан сумын нутаг Цантын хүр гэх газарт нутагладаг 11 дүгээр багийн малчин өрхийн гэрийг үерийн уснаас нүүлгэн шилжүүлсэн.	
3	Мэргэжлийн байгууллагатай хамтран иргэдэд үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг шуурхай хүргэх, сургалт дадлагын ажлыг шаардлагатай газруудад үе шаттай зохион байгуулах, аюул бүхий газруудыг тэмдэгжүүлэх	Сумын Засаг дарга нарт	Улс, аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын байгууллага, Ус цаг уур, орчны шинжилгээний газар зэрэг мэргэжлийн байгууллагуудаас ирүүлж буй цаг уурын болон аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ, сэрэмжлүүлгийг сумын Засаг даргын тамгын газар, багийн Засаг даргын ажлын албадын олон нийттэй харилцах хуудсаар дамжуулан тухай бүрт шуурхай дамжуулан ажилласан. Тус сумын 2 дугаар багийн нутагт Хэрлэн хороололд “Дорнод Нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-аас газар шорооны ажил хийж буйтай холбогдуулан ухагдсан нүх нь голын ус эргээ хальсаны улмаас дүүрч, түүгээр зорчиж буй хүн, тээврийн хэрэгсэл унаж осолдох эрдэлтэй болсон байсныг багийн Засаг даргын ажлын албаны зүгээс тууз татаж тэмдэгжүүлснээр болзошгүй осол, гэмтлээс урьдчилан сэргийлж ажилласан.	100
4	Үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээллийг хүргэх, эргүүл хяналт хийх, авран хамгаалах чиглэлээр сумын Онцгой комисс, шуурхай штаб, мэргэжлийн ангид дутагдалтай байгаа техник, багаж, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах	Сумын Засаг дарга нарт	Сумын мэргэжлийн ангид дутагдалтай байгаа тоног төхөөрөмжийн судалгааг гаргасны үндсэн дээр сумын Гамшгаас хамгаалах зардлаас өндөр хүчин чадалтай ус соруулах насосыг худалдан авч, ашиглалт хадгалалтад хяналт тавин ажиллаж байна. Цаашид дутагдаж буй хувцас хэрэгсэл, багаж төхөөрөмжийн судалгааг гаргаж ирэх жилийн Гамшгаас хамгаалах зардлаас худалдан авалт хийхээр төлөвлөн ажиллаж байна.	90
5	Үерийн эрсдэл бүхий голын голдирол, гуу жалга газар эрсдэлийн үнэлгээ хийж, үерт өртөж болзошгүй айл өрх, аж ахуйн	Сумын Засаг дарга нарт	Тус сумын 5 дугаар багийн нутаг Хэрлэн голын урд хэсэг, үерийн өндөр эрсдэл бүхий газарт тус сумын 1 дүгээр багийн иргэн зөвшөөрөлгүй бууж мал маллаж байгаа тухай	100

	<p>нэгжүүдэд аюултай бүсээс нүүн шилжих улсын байцаагчийн албан шаардлагыг нэг бүрчлэн өгч, үерийн гамшгаас учирч болзошгүй хор хохирлыг тайлбарлан таниулж, мэдээлэл сурталчилгаа, заавар зөвлөмжөөр хангаж, аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх</p>		<p>мэдээлэл хүлээн авснаар сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж, эрсдэл бүхий байршлаас нүүн шилжих тухай мэдэгдлийг хүргүүлэн, үерийн эрсдлээс урьдчилан сэргийлж ажилласан. Бороо ихээр орсон жилүүдэд эгнээ гудамжинд хуримтлагдсан усанд автдаг 11 дүгээр багийн Хивс хорооллын 4-6 дугаар эгнээ, 7-11 дүгээр эгнээний зүүн хэсгийн нийт 47 өрхийн 280 гаруй иргэнд урьдчилан сэргийлэх арга хэмжээний бэлтгэл бэлэн байдлыг хангах талаар сэрэмжлүүлэг мэдээллийг багийн Засаг даргын ажлын албанаас хүргүүлэн ажиллалаа. Бусад үерийн эрсдэлтэй бүсэд суурьшсан өрхийн хувьд зохих журмын дагуу тухайн газрыг өмчлөлийн журмаар авсан газар байгаа тул цаашид нөхцөл байдалтай уялдуулан зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p>	
<p>2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 02 дугаар албан даалгавар Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тухай</p>				
6	<p>Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 1.7.1-д заасныг хэрэгжүүлсэн хавар, намрын хуурайшилтын улиралд Засаг даргын захирамжаар хуваарь гарган ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан түймрийг илрүүлэх, шуурхай мэдээлэх, унтраах зорилгоор сум орон нутгийн хэмжээнд өндрийн харуул, хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтын цэгийг байгуулж, урамшуулалт эргүүлийг ажиллуулах, тэдгээрийг автомашин, техник, холбооны хэрэгсэл, шатахуунаар хангах, хөдөлгөөнт эргүүл, шалгалт хийх,</p>	Сумын Засаг дарга нарт	<p>Монгол Улсын Шадар сайдын “Гэр хорооллын айл өрхүүдийн гал түймрийн аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”, аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн баталсан удирдамжийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн “Гэр хорооллын айл, өрхүүдийн гал түймрийн аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх” удирдамжаар гэр хорооллын айл, өрх бүхий багийн Засаг дарга нарт сарын хугацаатай урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай үүрэг чиглэлийг хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулж ажилласан. Гэр хорооллын айл, өрх бүхий багийн 40 хувиас доошгүй айл, өрхүүдэд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах үзлэг шалгалтыг зохион байгууллаа. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд багийн Засаг даргын ажлын албад нь 125</p>	100

	шаардлагатай газар нутагт хяналтын цэг байгуулан ажиллуулахыг		хэсгийн ахлагчдаар дамжуулан гэр хороолол айл, өрхүүдэд галын аюулгүй байдал, пийшин, зуухны аюулгүй байдлын шалгалтыг 5977 өрхөд хийж, сурталчилан таниулах брошур, тараах материал 1169 ширхэгийг тарааж, олон нийтийн газар, дэлгүүр худалдааны төвүүдээр зурагт хуудас анхааруулга сэрэмжлүүлгийг байрлуулсан. Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, бүсийн төв Онцгой байдлын газраас хүргүүлдэг цаг агаарын болон гал түймрээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл олон нийтийн сүлжээ, веб хуудас, багийн ажлын албадаар дамжуулан тухай бүрд ард иргэдэд зарлан мэдээлж байна. Дэлхийн зөн олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төсөлд тус сумын 11 дүгээр багийн ажлын алба сонгогдож, төслийн хүрээнд ахуйн гал түймэр, орчны бохирдлоос сэргийлэх зорилгоор эх үүсвэр дээр нь хог ангилах савыг 39 өрхөд жишиг болгон хийж байрлуулснаар зорилтот бүлгийн 102 иргэн, 72 хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоогоор хангагдсан байна.	
7	Засгийн газрын 2023 оны 106 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасны дагуу сум, багийн нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгслийг бэлтгэх, бэлэн байдлыг хангуулахыг	Сумын Засаг дарга нарт	Ой хээрийн түймрийн аюултай үе буюу 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрүүдэд аймгийн Онцгой байдлын газрын жижүүрийн утсанд цагийн байдлыг тогтмол мэдээллэн ажиллах түймрийн хариуцлагатай жижүүрийн хуваарийг сумын Засаг даргаар батлуулан, өдөр тутам мэдээлэл хүргэн ажилласан.	100
8	Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, түймэр унтраах 1,2 дугаар бүлгийг тус бүр 12-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэй томилж бэлэн байдлыг хангуулах, зэргэлдээх аймаг, сумын хилийн зааг дээр гарсан түймрийг нутаг дэвсгэрийн	Сумын Засаг дарга нарт	Сумын Засаг даргын 2023 оны А/144 дүгээр захирамжаар Гал түймэр унтраах 1, 2 дугаар бүлгийн бүрэлдэхүүнийг тус бүр 12, нийт 24 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд бие бүрэлдэхүүнд тухай бүр тодотгол хийж, байнгын бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 2 удаа тодотгосон.	100

	харьяалал харгалзахгүй хамтран шуурхай унтрааж ажиллахыг			
9	Малчин өрхүүдийг бүлэг багийн зохион байгуулалтад оруулж, түймрээс хамгаалах зурвас татах ажлыг ил гал гаргахгүй хийж, түймэр унтраах багаж, хэрэгслийг хамтран бүрдүүлж, урьдчилан сэргийлэх ажилд малчин иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийг	Сумын Засаг дарга нарт	Гал түймрээс хамгаалах зурвас татах ажлыг ил гал гаргалгүйгээр хийж, гэр байр, эд хөрөнгөө болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар мэдээлэл сурталчилгааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хавар намрын улиралд тогтмол нэвтрүүлэн ажиллаж байна. Гарын доорх материал ашиглан гал түймэр унтраах багаж хэрэгслийг хийх арга зааварчилгааг Гамшигт тэсвэртэй орон нутаг төслөөс бэлтгэгдсэн сургагч багш нараар дамжуулан ард иргэдэд сурталчлан ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 39 өрхөд мэдээллийг хүргэн ажилласан байна.	90
10	Аймгийн Засаг даргын баталсан “Аймгийн хэмжээнд тохиолдсон гамшгийн голомтыг цомхотгох, тархалтыг зогсооход зарцуулсан зардлыг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам”-ыг хэрэгжүүлж ажиллах	Сумын Засаг дарга нарт	Аймгийн Засаг даргын баталсан “Аймгийн хэмжээнд тохиолдсон гамшгийн голомтыг цомхотгох, тархалтыг зогсооход зарцуулсан зардлыг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам”-ыг хяналтадаа авч, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	100
2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 03 дугаар албан даалгавар				
Зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах арга хэмжээг зохион байгуулах тухай				
11	Сумын хэмжээнд ажлын хэсэг байгуулж зуданд зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэм устгах үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, шаардагдах хүн хүч, машин техник, шатахуун томилолтын зардлыг батлах	Сумын Засаг дарга нарт	Хэрлэн сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 06 ны өдрийн А/118, 172 дугаар захирамжийн хүрээнд сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлыг хэсэг томилогдон, зуданд зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэм устгах үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 06 ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх 45 хоногийн хугацаанд сумын Засаг даргын орлогч, сумын Мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн, сумын Батлан хамгаалах, Онцгой байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн, сумын Хөдөө аж	

			<p>ахуй тасгийн мэргэжилтэн, сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, сумын Байгаль хамгаалагч, сумын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, Дорнод “Нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын экскаваторын жолооч 1, сумын газрын даамал, 1-11 багийн Засаг дарга нар, “Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын ковшны жолооч 2, ачааны машины жолооч-2, ачигч-2 нийт 27 хүний бүрэлдэхүүнтэйтэй, Үүсмэл болон зүй бусаар хорогдсон малын сэг зэм цуглуулах, устгаж булах ажилд 15000000 сая төгрөгийн шатахуун, нэг удаагийн халдвар хамгааллын хувцас 200 ширхэг, бээлий 300 ширхэг, маск 500 ширхэг зарцууллаа. Нийт 32676 толгой үхсэн мал, амьтны сэг зэмийг устгаж, ариутгал халдваргүйтгэлийг 100 хувийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэлээ.</p>	
12	<p>Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, бэлчээр, уст цэг, үерийн жалга, усны эх булгийг цэвэрлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах</p>	Сумын Засаг дарга нарт	<p>Хэрлэн сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 06 ны өдрийн А/118, 172 дугаар захирамжийн хүрээнд сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлыг хэсэг нутаг дэвсгэртээ гамшгийн улмаас хорогдсон 32676 мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, бэлчээр, уст цэг, үерийн жалга, усны эх булгийг цэвэрлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллалаа.</p>	
13	<p>Сэг зэм устгалын цэгийг тогтоох Байгаль орчны хяналтын улсын байцаагчаас зөвлөмж авч, шинээр устгалын цэг нэмэхдээ Байгаль орчин аялал жуулчлалын газарт мэдэгдэж бүртгүүлэх</p>	Сумын Засаг дарга нарт	3.Цолмончимэг	
14	<p>Мал амьтны сэг зэмийг цуглуулж устгахдаа зураглалын дагуу харьяалах сумын нутаг дэвсгэр, хилийн цэс, заагийг бүрэн хамруулж, гол булаг, шанд, худаг, уст цэгүүд, улсын чанартай авто зам, уст цэгүүд, улсын чанартай авто зам,</p>	Сумын Засаг дарга нарт	<p>Мал амьтны сэг зэмийг цуглуулж устгахдаа зураглалын дагуу харьяалах, сумын нутаг дэвсгэр, хилийн цэс, заагийг бүрэн хамруулж, гол булаг, шанд, худаг, уст цэгүүд, улсын чанартай авто зам, хөрш зэргэлдээ аймаг, аймгаас сумд руу гарах, орох чиглэлийн зам дагуу хорогдсон мал, амьтны сэг</p>	

	хөрш зэргэлдээ аймаг, аймгаас сумд руу гарах, орох чиглэлийн зам дагуу хорогдсон мал, амьтны сэг зэмийг тус тус цуглуулж устгал, халдваргүйтгэл хийх		зэмийг тус тус цуглуулж булж устгасан. нийт 15000м2 талбайн халдваргүйжүүлэлтэд Супир Килл ариутгалын бодисыг 39 кг, Хайкоф 14 кг нийт 53 кг ариутгалын бодисыг зарцууллаа. хийх	
15	Өөр сумаас оторлож байгаа малчин өрхийн зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг тухайн малчны одоо нутаглаж байгаа суманд цуглуулж устгах ба уг ажилд тухайн сум, багийн Засаг дарга нар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн дагуу тухайн суурийн малчныг оролцуулах	Сумын Засаг дарга нарт	Тус сумын нутагт өөр сумаас оторлож ирсэн малчин өрх байхгүй болно.	
16	Мал амьтны сэг зэмийг цуглуулж, устгах, халдваргүйтгэх арга хэмжээг гүйцэтгэх ажиллагаанд оролцож байгаа ажилтнуудад машин техникийг ажиллуулах, нүх ухах, сэг зэмийг зөөвөрлөх тээвэрлэхийн өмнө хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч аюулгүй байдлыг хангуулж ажиллах	Сумын Засаг дарга нарт	Мал амьтны сэг зэмийг цуглуулж, устгах, халдваргүйтгэх арга хэмжээг гүйцэтгэх ажиллагаанд оролцож байгаа ажилтнуудад машин техникийг ажиллуулах, нүх ухах, сэг зэмийг зөөвөрлөх тээвэрлэхийн өмнө хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч аюулгүй байдлыг хангуулж өдөр бүр жолооч, ачигч нараар гарын үсэг зуруулж, хөдөлмөр хамгаалалын хувцсаар хангаж ажиллалаа.	
2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 04 дүгээр албан даалгавар Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай				
17	Хөдөө аж ахуйн салбарын болон сум суурин газрын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах	Сумын Засаг дарга нарт	ЗАА Өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах тухай сумын Засаг даргын 2024 оны А/316 дугаар захирамжийг багийн ажлын албадаар дамжуулан албан байгууллага, аж ахуйн нэгж, Сууц өмчлөгчдийн холбоодод хүргэн, биелэлтийг ханган ажилласан. Үүнд: 1. ЕБСургууль цэцэрлэгүүд - Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд анги танхимын цонх дулаалах, шугам паар угаах,	100 хувь

		<p>хагарч цоорсныг солих, хүйтэн усны дотор шугамыг солих, цэвэр усны шугамын цөмөрсөн нүхийг шороогоор булж, тэгшлэх, гаднах худгуудыг лайдаж цэвэрлэн, дулаалах зэрэг ажлуудыг гүйцэтгэн “ДБЭХС” ТӨК-тай гэрээ байгуулан дулаанаар хангагдаж, хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулж байна. 12 дугаар сургуулийн дээврийн засварыг “Донж Өргөө” ХХК 100% гүйцэтгэсэн. Хүүхдийн хоол хүнсний нөөцийг ажлын 5-14 хоногоор татан авч, амт тэжээллэг чанарт анхаарч ажилласан.</p> <p>2. Сууц өмчлөгчдийн холбоод - Чойбалсан хотод 30 СӨХ үйл ажиллагаа явуулж “Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-тай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна. Орон сууцны байрын зоорины давхрын хэрэглээний халуун хүйтэн усны хаалт шинэчлэх, чардакны хаалгыг солих, ариутгал халдваргүйтгэл зэргийг хийсэн. Мөн 49 орцны 167 цонхыг шиллэж 15 хаалганд кодтой цоож хийсэн. Хуучны орон сууцны байрны дулаан алдагдлыг бууруулах зорилгоор сумын Орон нутгийн хөгжлийн сан болон сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 28 байрны 107 орцны хаалгыг шинэчлэн сольсон.</p> <p>3. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд: “Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийт 72 ажил төлөвлөж 94 хувьтай гүйцэтгэсэн. Чойбалсан хотын орон сууцны байруудын халаалтыг Эрчим хүчний сайдын тушаалаар 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дулаанаар хангаж эхэлсэн. Айл өрхүүдэд дулаан өгч эхэлсэнтэй холбогдуулан 1 дүгээр багийн “Илч” хороолол, 6 дугаар багийн “Ивээл” хорооллын дулааны шугам сүлжээнд байнгын гэмтэл гарч, засварын ажлыг гүйцэтгэсэн. Энэ онд орон сууцны 1-8, 19, 20 дугаар байр, 1 болон Flower сургууль, 10 дугаар цэцэрлэг, МАН, АН-ын байр, LUX, Их тал, Айсвн, орон сууцны 20-р байрны</p>	
--	--	---	--

		<p>урд талын граж, ААН-үүдийн дулааны шугамыг дулаан дамжуулах төвд буюу дулаан хангамжийн 2-р хэлхээнд холбож, дулааны доголдол арилж, дулаан хангамж ижил түвшинтэй болсон. Залуус хорооллын 179 айлын 58 айл нь халуун хүйтэн усны шугамын хоолой нь стандартын бус хар хоолойгоор хийгдсэн байдаг. Үүнийг 2024 онд аймгийн төсвийн 140,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цайрдсан хоолойгоор сольсон.</p> <p>“Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ - Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу “техникийн шалгалтын комисс” байгуулан бүх тээврийн хэрэгсэлд үзлэг явуулж, 9 тээврийн хэрэгсэлд шаардлагатай засвар үйлчилгээг хийн, 18 тээврийн хэрэгслийн тос, тослогоог сольсон. Хог тээврийн 18 тээврийн хэрэгсэл хэвийн ажиллаж байна.</p> <p>“Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ - Чойбалсан хотын нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, арчлалтад хог тээврийн машин 2, жолооч 2, зам талбайн үйлчлэгч 12, зохион байгуулагч 1 гэсэн бүрэлдэхүүнтэйгээр өдөр тутмын үйл ажиллагааг явуулдаг. Тусгай зориулалттай 2 тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг ханган үйл ажиллагаанд бэлтгэсэн. Гудамж, зам талбайн мөстөлтөөс хамгаалах зорилгоор 10 тн давс, элсний холимог нөөцлөөд байна. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тооллого явуулахад нийт 5139 гэрэлтүүлгээс 1161 гэрэлтүүлэг гэмтэлтэй, асахгүй байна. Гэрэлтүүлгийн асалт 77,4 хувь байна. Мөн 147 суурийн 751 гэрэл бүхий цамхагт гэрэлтүүлгээс 232 гэрэл гэмтэлтэй асахгүй, цамхагт гэрэлтүүлгийн асалт 69.2 хувь байна</p>	
--	--	--	--

18	Албан даалгаврын хавсралтад заасны дагуу малчдын болон аймаг, сумын аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг бүрэн бэлтгэж, агуулахад бүрэн татаж төвлөрүүлсэн байх	Сумын Засаг дарга нарт	<p>“Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын Засаг даргын “А/316 дугаар захирамж гарч, сумын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах ажлын төлөвлөгөө гарган, сумын Засаг даргаар батлуулж, багуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин биелэлтийг ханган ажиллаж байна.</p> <p>Сумын хэмжээнд малчдын түвшинд өвс 6974,5 тн бэлтгэхээс 7089,4 тн буюу 100 хувь, 35 тн тэжээл бэлтгэхээс 38,1 тн буюу 100 хувь бэлтгээд байна.</p> <p>Сумын аюулгүй нөөцийн өвс 100 тн буюу 100 хувь, тэжээл 30 тн бэлтгэхээс 30 тн буюу 100 хувь бэлтгэн стандартын шаардлага хангасан агуулахад нөөцлөөд байна.</p>	
19	Өвөлжих болон хэрэгцээлэх малыг малын төрөл, сүргийн зохистой харьцаанд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг хуваарь, төлөвлөгөө гарган зохион байгуулах	Сумын Засаг дарга нарт	Тус сумын малчин болон мал бүхий иргэд мал сүргийнхээ зохистой харьцааг хадгалж 2024 онд 9084 толгой амьд мал, 75,6 тн махыг хэрэгцээт зах зээлд нийлүүлсэн байна.	
20	Малчин өрх бүрийн малын тоо толгойг харгалзан түүнд шаардлагатай хадлан, тэжээл, гар болон эрдэсжүүлсэн тэжээл бэлтгүүлэх	Сумын Засаг дарга нарт	Аймгийн Засаг даргын 04 дүгээр албан даалгавар сумын Засаг даргын 2024 оны 316 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган малчдын түвшинд 7089,1 тн өвс, 38,1 тн тэжээл бэлтгээд байна.	
21	Малын гоц халдварт шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг технологийн хугацаанд чанартай зохион байгуулж, мал	Сумын Засаг дарга нарт	<p>Малын халдварт, шимэгчтэх өвчний төлөвлөгөөг сумын түвшинд боловсруулан Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний</p>	

<p>эмнэлгийн удирдлага үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах</p>		<p>өдрийн 16/03 тогтоолоор шимэгчтэх өвчний төлөвлөгөөг батлуулан ажиллаж сэргийлэх төлөвлөгөөг оруулсан. Сумын Засаг даргын А/164 дүгээр захирамжийн хүрээнд Гуурын боловсруулалтад 7799 толгой үхэр, боловсруулалтад 7799 үхэр толгой Адуу 1000 толгой, хонь 37598 толгой, ямаа 12410 толгой нийт 59008 толгой мал, туулгалтад 1000 толгой адуу, үхэр 7799 толгой хонь 23870 толгой, ямаа 11461 толгой нохой 400 нийт 44530 толгой мал, амьтан, Бод, бог мал угаалганд үхэр 3509 толгой, хонь 37598 толгой, ямаа 12410 толгой нийт 53517 толгой мал нийт 28906 толгой бод, 135347 толгой бог, 400 толгой нохой нийт 189264 толгой мал, амьтан давхардсан тоогоор шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрууллаа. Сумын Засаг даргын 2024 оны А/157 тоот захирамжуудын хүрээнд “АЖХ” ХХК, “Түмэн эрүүл мал” ХХК, “Рашаан бүрд”, “Ветпом” ХХК-ийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нар бод, бог малд Цусан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд өрхийн 2960 толгой үхэр, 2830 толгой хонь, 2370 толгой ямаа нийт 8160 толгой бод, бог мал, Дуут хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 5989 толгой үхэр, Гахайн цусан</p>	
--	--	---	--

			<p>халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 1356 толгой гахай, Дотрын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 7997 толгой бог мал, Сахуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 400 толгой унага, Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 3000 толгой богийн төл малыг хамруулан ажиллалаа. нийт давхардсан тоогоор бод 9349 толгой, бог 16197 толгой амьтан 1356 нийт 26902 толгой малыг дархлаажуулалтад хамрууллаа.</p> <p>Түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах цэг, зоорь, тэжээлийн агуулах 3000 м2, Малын хашаа, хороо, мал амьтны тоног хэрэгсэл, худаг, уст цэг 47600м2, Бэлчээрийн талбайн сэг зэм устгал 16000м2, Халдваргүйжүүлсэн бүс , цэг 14800м2, Бэлчээрийн талбай 142927м2 нийт 224327м2 талбай халдваргүйжүүлэлтэд Супир Килл ариутгалын бодис Хайкоф 14 кг нийт 58кг нийт 72 кг ариутгалын бодисыг зарцууллаа.</p>	
22	Малын гоц халдварт өвчин гарсан сумын голомт үүсч байсан бүс нутгийн малчдад өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	Сумын Засаг дарга нарт	Малын гоц халдварт өвчин гараагүй. Сумын малчин, мал бүхий иргэдэд малын гоц халдварт, халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төсөлтэй хамтран 1-11 багийн малчин 284 малчин, 125 мал бүхий, 15 иргэд нийт	

			424 малчин, мал бүхий иргэдэд хүрч мэдээ, мэдээллийг хүргэж ажиллалаа.	
23	Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн “Урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээг хэрэгжүүлэх” заалтууд, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам”-ын дагуу малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллаж	Сумын Засаг дарга нарт	Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн “Урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээг хэрэгжүүлэх” заалтууд, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам”-ын дагуу сумын хэмжээнд малын шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна.	
24	Орон нутгийн төсвийн болон төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгөөр шинээр инженерийн хийцтэй худаг болон цооног гаргах ажлын явцад гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг эрчимжүүлэх	Сумын Засаг дарга нарт	Малчин өрхийн ундны усны хэрэгцээнд зориулж 5 дугаар багийн нутагт инженерийн хийцтэй гүн өрмийн худаг 3 г гаргасан.	
25	Өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангуулахаар багуудад ажлын хэсэг томилж, өвөлжилтийн бэлтгэлийг газар дээр нь үзэж, малчин өрх бүрээр гарын үсэг зуруулж, баталгаажуулах	Сумын Засаг дарга нарт	Сумын Засаг даргын “2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” А/316 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангуулах, хадлан, гар тэжээл бэлтгүүлэх, мал сүргийг оторлон таргалуулах, тарга хүчийг нь тогтоох, малын хашаа, саравчаа засварлан сэргээх, талаар зөвлөмж, уриалга гарган, багийн Засаг даргын ажлын албадаар дамжуулан малчдад хүргэж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.	
26	Ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийг сайтар бэлтгэж, цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацаа хамгаалах,	Сумын Засаг дарга нарт	Малчид өвөлжилт, хаваржилтад зориулж 6974,5 тн өвс, 35 тн тэжээл бэлтгэхээс 7089,4 тн өвс, 38,1 тн тэжээл бэлтгээд	

	урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллах		байна. Үүнээс 1690,9 тн-ыг өөрсдөө хадаж, 5443,5 тн-ыг зах зээлээс худалдаж авсан. Энэ жилийн хадлан бэлтгэх ажилд 15 дугуйт трактор, 21 бага оврын трактор, 38 иргэн Баянтүмэн, Чойбалсан, Матад, Цагаан овоо, Халх гол сумдад хадлан хадсан. Хадлангийн 6 салаа гарч нийт 120 орчим хүн ажиллаж, түр ажлын байраар хангагдсан. Ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийг сайтар бэлдэж цаг агаарын аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх талаар тариаланч болон иргэдэд багийн ажлын албаны page хуудас болон сумын page хуудсаар дамжуулан сэрэмжлүүлэг хүргэн ажилласан.	
27	Өвөл хаврын цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх	Сумын Засаг дарга нарт	Өвөл, хаврын цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын онцгой комисс Гамшигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган түүний дагуу иргэдэд сэрэмжлүүлэг мэдээг 11 багийн ажлын алба болон сумын page хуудсаар дамжуулан хүргэн ажиллаж байна.	
28	Малчдыг малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах гурил, тэжээлийн үйлдвэрүүдтэй гэрээ байгуулан малаа зарж борлуулан хэрэгцээт тэжээлийн нөөц бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах	Сумын Засаг дарга нарт	“ Дорнод мах маркет “ ХХК - малчдаас амьд мал болон махыг өндөр үнээр олон тоогоор газар дээр очиж худалдан авч байгаа, ОХУ - ын хивэг тэжээлийг бэлэн мөнгөөр болон бартерээр нийлүүлэх боломж, МУ - ЗГ ын хэлэлцээрээр амьд эм хонь болон эм хурга худалдан авч гадаад зах зээлд нийлүүлж байгаа зэрэг бусад хэрэгцээт мэдээлэлийг малчдад хүргэж ажиллаж байна.	
29	Сумын хэмжээнд эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж мал бордох аж ахуйг хөгжүүлэх, хүн амын хүнсний хэрэгцээнд стандартын шаардлага хангасан шинэ болон нөөцийн махыг бэлтгэх ажлыг	Сумын Засаг дарга нарт	Сумын хэмжээнд мах бэлтгэн нийлүүлэх 5 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаагаас Талын таван өндөр ХХК, Дорнод мах маркет ХХК, Вайтгрүп ХХК зэрэг газрууд мал нядалгаанд оруулж, Хаан хүнс ХХК, Хөвчийн талын баялаг ХХК газрууд бэлтгэсэн махыг худалдан авч төвлөрүүлдэг ба	

	мэргэжлийн байгууллагын чиглэлийн дагуу зохион байгуулах		<p>үйлдвэрүүд өдөрт бог 35-40тн, бод 170-200тн-ыг бэлтгэж, бэлтгэсэн мах сард бог 760-800тн, бод 3500-4000тн-ыг бэлтгэж байна.</p> <p>Нөөцийн маханд бэлтгэх төлөвлөгөө Талын таван өндөр ХХК 400тн, Дорнод мах маркет ХХК 400тн, Вайтгрүп ХХК 300тн, Хаан хүнс ХХК 35тн, Хөвчийн талын баялаг ХХК 100тн нийт 1100тн махыг нийцийн маханд бэлтгэхээр төлөвлөгөөтэй байна.</p>	
30	Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явц, ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэл, мал эмнэлгийн технологит ажил үйлчилгээний мэдээг 7 хоног тутамд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газарт тогтмол мэдээлэх	Сумын Засаг дарга нарт	Сумын Засаг даргын “2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” А/316 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гарсан төлөвлөгөөний дагуу долоо хоног бүр аймгийн ХХААГазарт мэдээ, мэдээлэл өгч, өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангуулах, орон нутгийн нөөц боломжийг түшиглэн хадлан, гар тэжээл бэлтгүүлэх, мал сүргийг оторлон таргалуулах, тарга хүчийг нь тогтоох болон цаг үеийн ажлыг эрчимжүүлэх талаар зөвлөмж гарган, багийн ажлын албаар дамжуулан малчдад хүргэж хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавин ажиллалаа.	
31	Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, орлого бүрдүүлэлтэд хяналт тавих ажлыг эрчимжүүлэн ажиллах	Сумын Засаг дарга нарт	“ Хүн ам, өрхийн мэдээллийн санг шинэчилж, мал тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого явуулах тухай” 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 10 хоногийн хугацаатай эхэлсэн ба алсалагдсан айл өрхийн тооллогыг амжилттай зохион байгуулж ирсэн.Уг хугацаанд сумын Засаг даргын 2024 оны А/468 дугаар захирамж, сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 3/1304 албан тоотын хэрэгжилтийг хангаж	90

			ажиллах, мөн өвөлжилтийн бэлтгэл, томуу, томуу төст халдварт өвчний талаарх заавар зөвлөгөөг хүргүүлж ажиллалаа. Малын тоо толгойн албан татварын орлого 2024 оны бүрдүүлэлт 54,375,080 төгрөг байна.	
Хэрлэн суманд хамааралтай 31 ажил, арга хэмжээ байна.				
Дундаж үнэлгээ			 хувь

ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР